



**АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

**Эмнэлгийн тусламж, үйлчилгээний
бэлэн байдлыг хангаж ажиллах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6, 109 дүгээр зүйлийн 109.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 тоот тушаал, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дүрмийн 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх нийтээр амрах баяр наадмын өдрүүдэд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт 2022 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн өглөөний 09.00 цагаас 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 09.00 цаг хүртэл ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, амралтын өдрүүдэд ажиллах журмыг хоёрдугаар, Эрүүл мэндийн яаманд өгөх мэдээний хүснэгтийг гуравдугаар, хариуцлагатай эргүүлийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хариуцлагатай жижүүр, албаны дарга, тасгийн эрхлэгч, ахлах эх баригч, ахлах сувилагч нарт Даалгах нь:

2.1. Бүх нийтээр амрах баяр наадмын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр нь тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг гуравдугаар хавсралтад заасан мэдээний хүснэгтийн дагуу өглөө бүр 07.00, орой бүр 20.00 цагт Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлын 99700420 дугаарын утсанд шуурхай мэдээллэх,

2.2. Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал нь тухайн өдрийн мэдээг нэгтгэн ерөнхий Захирлын 91916585 дугаарын утсанд өдөрт 1 удаа, онцгой тохиолдолд тухай бүрт нь шуурхай мэдээлэх,

2.3. Амралтын өдрүүдэд тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг тухайн өдрийн жижүүрийн ахлах эмч нар ЭМС-ын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан АМ-36 маягтын Статистикч, мэдээлэл зүйн албаны Статистикч Б.Мягмарсүрэнгийн 99786074 дугаарын утсанд өглөө бүр 07:00 цагт мэдээ өгөх, мэдээг нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд өдөр бүрийн өглөөний 08.00 цагт www.burtgel.mohs.mn цахим хаягаар оруулахыг үүрэг болгосугай.

2.4. Бүх нийтээр амрах баяр наадмын өдрүүдэд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтны анхаарал сулрах, хариуцлага алдах, ажлын байрыг орхиж явах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчлийг гаргахгүй байх, байнгын хяналт тавьж ажиллах,

2.4. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдалтай уялдуулан хариу арга хэмжээний бэлэн байдлыг шуурхай хангах, халдварын сэргийлэлт, хяналт, тандалтыг өндөржүүлж, хариуцлага, сахилга бат, дэг журмыг чанд сахих,

2.5. Бүх нийтээр амрах баяр наадмын өдрүүдэд амаржих газрын удирдлагын зөвлөлийн гишүүд, тасгийн эрхлэгч, ахлах эх баригч, ахлах сувилагч, эм зүйч, жолооч, инженер техникийн албаны ажилтнууд болон шаардлагатай бусад ажилтнууд өндөр сонор сэрэмжтэй байж, ямарч нөхцөлд холбоо барих боломжтой байх утсыг нээлттэй байлгах,

2.6. Бүх нийтээр амрах баяр наадмын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын ажлын цагийн хуваарийг гаргаж, ил тод байршуулж, сахилга хариуцлагыг өндөржүүлэн үүрэг чиглэлээр хангах,

2.7. Нэгдсэн хүлээн авах яаралтай тусламжийн тасаг, хэвтүүлэн эмчлэх тасгууд нь иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ ёс зүй, харилцаа хандлагын доголдолгүй, түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх,

2.8. Эмнэлгийн тусламж үйлчилгээний эмнэлзүйн заавар, стандартыг чанд мөрдөх, аюулгүй ажиллагааг хангах. Жирэмслэлт, төрөлттэй холбоотой тусламжийг шуурхай үзүүлэх, шалтгаан тодорхойгүй хэвлийн өвдөлттэй, хордлоготой, дайрлагын байдалтай нөхөн үржихүйн насны эмэгтэйд “Жирэмсний сорил”-ыг заавал тавьж, жирэмсэн эсэхийг тогтоож, шаардлагатай арга хэмжээг шуурхай авах,

2.9. Нийтийг хамарсан хоолны хордлого, осол гэмтэл, халдварт өвчин дэгдэлт болон эмнэлгийн тусламж үйлчилгээний ноцтой алдаа, зөрчил гарсан үед Эрүүл мэндийн яамны хариуцлагатай жижүүрт шууд мэдээлнэ. Утас 323002

3. Бүх нийтээр амрах баяр наадмын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалаар хангахыг Эм зүйн албаны дарга /Б.Даваадэмбэрэл/, өвчтний хоол, хүнсний зүйлийг хүрэлцэх хэмжээгээр нөөцөлж, хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллахыг “ЭММО” ХХК-ны захирал /Х.Энхтүвшин/, гал, ус, дулаан, цахилгааны аюулгүй байдлыг хангаж, учирч болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Инженер техникийн албаны дарга /Д.Галбадрах/, жолооч нарын ажиллах хуваарийг гаргаж танилцуулахыг Хангамж үйлчилгээ аж ахуйн албаны дарга /М.Мөнхболд/, Автомашины бэлэн байдлыг ханган шаардлагатай үед дуудагдан ажиллахыг жолооч /С.Буянхишиг/, /Б.Амарсанаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллахыг Дотоод хяналтын ажилтан Ө.Сүрнээ, амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажилласан болон хяналт хийсэн ажилтнуудыг хууль тогтоомжийн дагуу биеэр амруулахыг Хүний нөөцийн менежер /Б.Саранцэцэг/ нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ц.БАТБОЛД